



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 26

Номгон

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "а", "в", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам"-ын 1.3, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянлиг сумын Соёлын төв, Жаргалант сумын сургууль, Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 128 779 239.33 төгрөгийн өртөг бүхий хавсралтад заагдсан хөрөнгийг Баянлиг сумын сургууль, Баян-Ойт сургууль, Онцгой байдлын ерөнхий газарт үнэ төлбөргүй шилжүүлсүгэй.

2. Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг комисс томилон зохион байгуулж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэж, тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 04 дүгээр сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/th togtool2019 0118382



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 03-дугаар сарын
19-ний өдрийн 26 дугаар тогтоолын хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Аймаг /сум/-ын нэр	Байгууллагын нэр	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Өр	НБУ	Бүгд үнэ	Элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авсан байгууллага
1	Баянлиг сум	Соёлын төв	Шинэ сум барилга	02.15.14	1	1955444097,33	1 955 444 097,33		1 955 444 097,33	Баянлиг сумын Сургууль
2	Жаргалант сум	Сургууль	1-Р Хоолны тогоо	03.02.09	1	2700000,00	2 700 000,00	2 115 000,00	585 000,00	Баян-Ойт цогцолбор сургууль
3	Баянцагаан сум	Засаг даргын Тамгын газар	Өвсний фондын барилга	09.01.16	1	170635142,00	170 635 142,00	6 635 811,00	163 999 331,00	Онцгой байдлын ерөнхий газар
		Дүн				2128779239,33	2128779239,33	8750811,00	2120028428,33	

ооо